

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
	2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
	2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
	2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
	2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
	2.14. Хязгаарлалттай санал дүгнэлт	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗТХЯ	Зам, Тээврийн хөгжлийн яам
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Р.БАТСҮХ ТАНАА

2020.03.13 № 06/863
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Азийн хөгжлийн банкны 40.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр МОН-2719/0240 дугаартай “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн байна. ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 218 дугаар тогтоолоор төслийн 107,856.9 сая төгрөгийн хөрөнгө Монголын төмөр зам ТӨХК-ийн хөрөнгийн дансанд бүртгэгдсэн бөгөөд Азийн хөгжлийн банкны зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээг Сангийн Яамтай байгуулаагүй, гэрээний эргэн төлөлтийн график тодорхойгүй;
- Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын дагуу “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд хийгдсэн гэрээт ажлуудын төлбөрийг Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх, санхүүжилтийг улсын төсвөөс эргэн төлөхөөр шийдвэрлэсэн боловч уг санхүүжилт зохих ёсоор олгогдоогүй байна. Ажил гүйцэтгэгч нарын нэхэмжлэлээр үүссэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй 10,417.7 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй


зэрэг нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Монголын төмөр зам ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Батсүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид санхүүгийн тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж байх, гадаад валютаар бүртгэгдсэн гүйлгээг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний Аудитын газрын захиалгаар Аккурэйт финанс аудит ХХК-ийн баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын төмөр зам ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Монголын төмөр зам ХХК-ийн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/168 дугаар бүхий албан бичгээр Үндэсний Аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын төмөр зам ТӨХК-ийн эрхэм зорилго нь Дэлхийд тэргүүлэгч төмөр замын тээвэрлэгч болох, Монгол Улсын төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани болоход оршино.

Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төмөр замын суурь бүтэц барих,
- Төмөр замын тээвэр зуучлал,
- Төмөр замын тээвэрлэлт,

Монгол Улсын засгийн газрын 2013 оны 152 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “Монгол-Тяньжины Дунзян тээвэр, ложистикийн төв” төслийг Хятадын талтай хамтран хэрэгжүүлэх Монголын талын төлөөлөл “Монголиан порт групп” ХХК-ийг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал болон 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Монголиан порт групп” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр үүсгэн байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай заалт нэмж, өөрчлөлт оруулсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Монголын төмөр зам ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус Монголын төмөр зам ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Монголын төмөр зам ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монголын төмөр зам ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын үзүүлэлтийг сонгож материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Монголын төмөр зам ТӨХК нь үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг ч орлогын зарцуулалт илүү анхаарал татах чухал үзүүлэлт гэж үзэн сонгов.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор охин компани байгуулан үйл ажиллагаа нь өргөжин төмөр зам барих зэрэг эрсдэлтэй гэж үзсэн тул 1 хувиар тогтоолоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,744.9 сая төгрөгөөс тооцон 57.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 99.0 сая төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 469,267.9 сая төгрөгөөр буюу 57.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,818.5	160,855.6	151,037.1
Авлага	11,131.3	10,212.7	-918.6
Урьдчилгаа	31,194.4	211,770.1	180,575.7
Бараа материал	458,193.8	489,710.0	31,516.2
Үндсэн хөрөнгө	311,497.4	418,554.9	107,057.5
Нийт хөрөнгө	821,835.4	1,291,103.3	469,267.9
Өр төлбөр	1,323.1	2,746.5	1,423.4
Хүүгийн өглөг	11,160.4	8,826.9	-2,333.5
Урт хугацаат өр төлбөр	94,331.5	555,774.5	461,443.0
Эздийн өмч	264,642.9	20,727.6	-243,915.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139.3	139.3	-
Эздийн өмчийн бусад хэсэг	516,956.8	767,531.6	250,574.8
Хуримтлагдсан үр дүн	-66,718.6	-64,643.1	2,075.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	821,835.4	1,291,103.3	469,267.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 151,037.1 сая төгрөгөөр өссөн нь Тавантолгойгоос Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах төслийг “Монголын төмөр зам” ТӨХК хүүгүй 20 жилийн хугацаатай 750 орчим тэрбум төгрөгийн үнэ бүхий үнэт цаас гаргаснаас бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө байна. Уг үнэт цаасыг нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгаж, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК худалдан авах замаар санхүүжүүлж байна.

Авлага дансны үлдэгдэл 918.6 сая төгрөгөөр буурсан нь Замын Үүдийн шилжүүлэн ачих байгууллагаас авах авлага 81.0 сая төгрөгөөр, бусад авлага 51.3 сая төгрөгөөр, Тавцант вагон, Битүү вагоны түрээсийн авлага оны эхний үлдэгдлээс 28.1 сая төгрөгөөр, НӨАТ-ын авлага 838.0 сая төгрөгөөр буурсан нь шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд тавцант, бүтүү вагон түрээслүүлсний УБТЗ ХНН-ээс авах авлага 28.8 сая төгрөг, Мидасложистик ХХК-иас 14.8 сая төгрөг, Ганхүдэр Орд ХХК-иас 13.3 сая төгрөгийн авлага байна. Мөн НӨАТ-ын авлага 8.639.7 сая төгрөг байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэж байгаа ажлын урьдчилгаа төлбөрүүд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 33,982.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч 2,466.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 14,266.0 сая төгрөгийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бараа материал, 205.1 сая төгрөгийн шатах тослох материал, 729.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 28,368.4 сая төгрөгийн барилгын материал, 24.6 сая төгрөгийн багаж хэрэгсэл, 54.7 сая төгрөгийн хангамжийн материал, 602.0 сая төгрөгийн вагон сэлбэг тус тус байна.

Оны эцэст 14,109.4 мянган төгрөгийн 13800 ш 1520 мм төмөр бетон дэр, хангамжийн материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Хөрөнгө оруулалтаар “Бүс нутгийн логикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240” төслийн 107,856.9 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 218 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн хөрөнгийн дансанд бүртгэгдсэн нь үндсэн хөрөнгийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Биет бус хөрөнгө программ хангамж хасагдуулгын дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд байгууллага хоорондын өглөг 579.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд харилцагч байгууллагуудад гэрээт ажил гүйцэтгүүлсэн төлбөр 1,889.2 сая төгрөг, орлогын татварын өглөг 386.0 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 8,826.9 сая төгрөг, ХХОАТ-ын өглөг 8,923.8 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр нь БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн зээл, “Бүс нутгийн логикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл 198,774.4 сая төгрөг, урт хугацаат бондын өглөг 357,000.0 сая төгрөг байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ТУЗ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 15 дугаар тогтоолоор баталж, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 465 дугаар тогтоолоор тодотгол хийж Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд компанийн илчит тэрэг, вагон түрээс, тээвэрлэлтээс нийт 14,637.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, удирдлага болон үйл ажиллагааны зардалд 13,126.0 сая төгрөгийн зардал гаргаж 1,511.8 сая төгрөгийн ашигтай ажиллагааар төлөвлөсөн байна.

Тайлант онд илчит тэрэг, вагон түрээсээс 6,230.0 сая төгрөг, тээвэрлэлтээс 3,946.8 сая төгрөг, хүүгийн орлого 4,982.2 сая төгрөг, бусад орлого 7,7 сая төгрөг нийт 15,166.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 528.9 сая төгрөгөөр давсан нь хүүгийн орлого, бусад орлого өссөнөөс шалтгаалжээ.

Нийт 13,126.0 сая төгрөгийн зардал төлөвлөн ажиллаж 9,081.1 сая төгрөгийн зардал гарган 4,044.8 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Батлагдсан зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл 15,166.8 сая төгрөг буюу 104 хувьтай байна.

Зардлуудаас материаллаг дүнтэй дутуу зарцуулалтын шалтгааныг авч үзэхэд:

- Үндсэн үйл ажиллагаанд 9,152.6 сая төгрөг төлөвлөснөөс 5,899.5 сая төгрөг зарцуулж гүйцэтгэл 64 хувьтай байгаа нь орон тоо, цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бичиг хэргийн зардал, зээлийн хүүгийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлууд төлөвлөсөн хэмжээнээс буурсан нь шалтгаалсан байна.
- Төмөртэйн Өртөөний үйл ажиллагаанд 3,973.3 сая төгрөг төлөвлөж 3,181.6 сая төгрөгийн зарцуулж 791.7 сая төгрөг хэмнэж гүйцэтгэл 80 хувьтай байна.
- Цалингийн зардал 2,108.5 сая төгрөгөөр төлөвлөж 1,850.9 сая төгрөгийн цалингийн зардал гарч 88 хувьтай байна. Энэ нь батлагдсан ажиллагсдын тоо 17-оор дутуу ажилласантай холбоотой.
- Зээлийн хүүгийн зардал 2,148.5 сая төгрөг төлөвлөснөөс 1,665.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Сэлбэг хэрэгсэл, авто машины засвар үйлчилгээний зардал 51.7 сая төгрөг төлөвлөснөөс 84,7 сая төгрөг зарцуулж 33.0 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлуудад томилолтоор ажиллах хугацаанд автомашины эвдрэл их гарсан нь шалтгаалсан байна.
- Шуудан холбооны зардал 8.5 сая төгрөг буюу 21.6 хувийн хэтрэлттэй байгаа нь Хандгайт өртөөний ачилтын талбайг ашиглахгүй байхаар зардлыг тооцоолсон боловч 2019 онд тээвэрлэлт ачилт хийж тухайн өртөөнд гарсан шуудан холбоо, интернэтийн төлбөрт тооцоо гарсантай холбоотой байна.
Энэ нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа ажилтай холбогдон гарсан зардлуудтай холбоотой байна.

Тайлант онд 2,573.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, ашгийн хэмжээг 1,061.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 10,491.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Монголын төмөр зам ТӨХК-ийн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр МОН-2719/0240 дугаартай “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 218 дугаар тогтоолоор 107,856.9 сая төгрөгийн хөрөнгө

Монголын төмөр зам ТӨХК-ийн хөрөнгийн дансанд бүртгэгдсэн бөгөөд Азийн хөгжлийн банкны зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээг Сангийн Яамтай байгуулаагүй, гэрээний эргэн төлөлтийн график тодорхойгүй байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн 407 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 750,000 /долоон зуун тавин мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16-д заасан зөвшөөрлийг Сангийн яамнаас авсны үндсэн дээр худалдахыг Монголын төмөр зам ТӨХК-д мэдэгдсэн байна.
- Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын дагуу хийгдсэн гэрээт ажлуудын төлбөрийг Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх, санхүүжилтийг улсын төсвөөс эргэн төлөхөөр шийдвэрлэсэн боловч уг санхүүжилт зохих ёсоор олгогдоогүй өнөөдрийг хүрсэн. Ажил гүйцэтгэгч нарын нэхэмжлэлээр үүссэн хэд хэдэн иргэний хэрэг шүүхийн шатанд хэлэлцэгдэж байна. Транскон ХХК-ийн гэрээний төлбөр, алданги 7,734.2 сая төгрөгийн нэхэмжлэл, Эко гидро гео ХХК-ийн гэрээний төлбөр, алданги 2,683.5 сая төгрөгийн нэхэмжлэл шүүхээр хэрхэн шийдвэрлэгдсэн эсэх;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн төслийн ажилтнуудын гадаад, дотоод томилолтын зардал зэргийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монголын төмөр зам ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. 2019 онд шилэн дансны цахим санд мэдээллүүдийг 7 төрлийн 62 мэдээллийг байршуулснаас 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 57,061.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж 1 албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 10,491.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 99.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Санхүүгийн тайланд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна “Хязгаарлалттай санал дүгнэлт”-ийн үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Харилцах дансны үлдэгдлийг шалган, тулган баталгаажуулалт хийхэд 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх долларын дансны үлдэгдэлд Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгээгүй 8.3 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалт болон НББОУС-21 “гадаад валютын ханшийн нөлөө” гэсэнтэй нийцээгүй, бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Мөнгөн хөрөнгө, касс ЖМС-ын анхан шатны баримтуудыг шалган үзэхэд хүний сугалааны дугаартай баримт 1.1 сая төгрөг, хүчин төгөлдөр бус баримт 5.8 сая төгрөг, нийт 6.9 сая төгрөгийн хүчингүй баримт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1. “анхан шатны баримт бүрдүүлэх” гэсэн заалттай нийцээгүй, бодитой оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар хөрвүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журам, СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2019 оны 12 сарын 31-ний байдлаар орлогын тайлангийн үйл ажиллагааны зардлаас түүвэрлэн шалгахад нийт зардлын ангилал зөрүүтэй 58.1 сая төгрөг байна. Үүнээс 47.2 сая төгрөгийн зардал нь татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал, үлдсэн 10.8 сая төгрөгийн зардал нь үндсэн үйл ажиллагааны зардлын дансны буруу ангилан тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимууд, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар”, энэ хуулийн 5.1.4-т заасан үнэн зөв байх гэсэн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” гэсэнтэй нийцээгүй, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, хууль тогтоомж хэрэгжихгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардлуудыг зөв ангилах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журам, СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд мөрдөж, цаашид анхаарч ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

3.3 Санхүүгийн тайлантай холбоотой

3.3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн үндсэн бүрэлдэхүүн болох Мөнгөн гүйлгээний тайланг өмнөх оны дүнтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1 дүгээр хавсралт Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд: 5.Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх” гэсэн заалт болон НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” гэсэн заалттай нийцээгүй, бодитой оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалт, зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөж ажиллах, зөрчлийг дахин давтахгүй байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

3.4 Өр төлбөртэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын дагуу “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд хийгдсэн гэрээт ажлуудын төлбөрийг Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх, санхүүжилтийг улсын төсвөөс эргэн төлөхөөр шийдвэрлэсэн боловч уг санхүүжилт зохих ёсоор олгогдоогүй байна. Ажил гүйцэтгэгч нарын нэхэмжлэлээр үүссэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй 10,417.7 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1.”Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, 6 дугаар зүйлийн 6.1 ”Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалт, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” гэсэнтэй нийцээгүй, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.4.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалт, зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журамуудыг мөрдөж ажиллах

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мерийн дугаар	Балансын үзүүлэлт	2018 оны 12 -р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,818,536,399.50	160,855,612,636.79
1.1.2	Дансны авлага	1,574,304,014.23	1,515,990,606.71
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	9,477,707,903.64	8,640,031,581.63
1.1.4	Бусад авлага	79,261,441.55	56,653,473.50
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	455,358,077,949.48	486,874,276,294.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31,194,408,178.31	211,770,156,069.13
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	2,835,708,700.00	2,835,708,700.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	510,338,004,586.71	872,548,429,362.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	67,523,282,683.06	174,581,067,375.55
1.2.2	Биет бус хөрөнгө	243,973,164,877.89	57,583,822.42
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	243,915,264,644.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	311,497,447,560.95	418,554,915,841.97
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	821,835,452,147.66	1,291,103,345,204.22
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,310,623,270.86	1,890,346,079.89

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	9,105,093.42	394,985,624.24
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	11,160,424,735.05	8,826,902,016.36
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,345,000.00	79,481,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	381,695,550.12
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,483,498,099.33	11,573,410,270.61
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	94,331,523,507.20	198,774,470,714.67
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	357,000,000,000.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	94,331,523,507.20	94,331,523,507.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	106,815,021,606.53	106,815,021,606.53
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	139,351,735.55	139,351,735.55
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	760,872,017,990.37	767,531,557,001.08
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-66,718,597,699.39	-64,643,103,032.29
2.3.11	Эздийн өмчийн дүн	715,020,430,541.13	723,755,464,218.94
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	821,835,452,147.66	1,291,103,345,204.22

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,618,057,475.32	3,946,808,321.35
2	Борлуулалтын өртөг	2,523,345,427.48	3,181,660,328.79
3	Нийт ашиг(алдагдал)	94,712,047.84	765,147,992.56
4	Түрээсийн орлого	6,071,096,630.78	6,230,039,965.46
5	Хүүгийн орлого	677,108,987.15	4,982,230,842.10
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,843,720,895.42	4,234,135,558.50
11	Санхүүгийн зардал	1,550,464,480.98	1,665,377,107.72
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8,509,090,285.19	-3,511,909,751.81
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-16,336,575.44	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	138,131,653.12	7,721,369.18
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-6,938,562,918.14	-6,938,562,918.14
19	Орлогын татварын зардал	67,710,898.71	498,223,084.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-7,006,273,816.85	2,075,494,667.10
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-7,006,273,816.85	2,075,494,667.10
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-7,006,273,816.85	2,075,494,667.10
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-7,006,273,816.85	2,075,494,667.10

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	-	516,982,356,207.67	-58,611,965,116.14	479,098,049,606.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	-	516,982,356,207.67	-58,611,965,116.14	479,098,049,606.13
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	-1,100,358,766.40	-1,100,358,766.40
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-25,602,861.30	-	-25,602,861.30
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-7,006,273,816.85	-7,006,273,816.85
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	139,351,735.55	243,915,264,644.00	-	244,054,616,79.55
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	760,872,017,990.37	-66,718,597,699.39	715,020,430,541.13
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	760,872,017,990.37	-66,718,597,699.39	715,020,430,541.13
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	6,659,539,010.71	-	6,659,539,010.71
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,075,494,667.10	2,075,494,667.10
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	244,054,616,79.55
18	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	767,531,557,001.08	-64,643,103,032.29	723,755,464,218.94

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9 014 561 557,72	8,543,536,582.34
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,609,681,680.80	8,496,468,506.88
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,770,647.00	16,125,780.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	402,109,229.92	30,942,295,46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,418,820,985.36	13,113,441,006.52
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,209,853,785.82	2,735,409,790.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	597,143,982.34	785,772,529.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	264,513,791.79	2,709,129,428.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	26,431,627.51	46,103,564.87
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	36,632,037.33	-
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	500,000,000.00	4,280,235,549.98
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,546,573,270.19	480,623,051.71
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,237,572,490.38	2,076,167,092.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-404,259,427.64	-4,569,904,424.18
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	677,108,987.15	4,982,230,842.10
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	677,108,987.15	4,982,230,842.10
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	171,192,676.90	206,378,385,848.32
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	1,000,000.00	33,587,610,546.81
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	170,192,676.90	172,790,775,301.51
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	505,916,310.25	201,396,155,006.22
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	357,000,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	357,000,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	357,000,000,000.00
4	Валютын ханшийн зөрүү	83,016,003.83	3,135,667.69
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	184,672,886.44	151,037,076,237.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,633,863,513.06	9,818,536,399.50
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,818,536,399.50	160,855,612,636.79

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодрууллагад хийсэн аудитын тайлан	Аудитын код:
2019.03.10			САГ-2020/9/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монголын төмөр зам ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
1	Харилцах дансны үлдэгдлийг шалган, тулган баталгаажуулалт хийхэд 2019 оны 12 сарын 31-ээрх долларын дансны үлдэгдэлд Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгээгүй 8.3 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	8.3	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Р.Батсүх Д.Даваадорж
2	Мөнгөн хөрөнгө, касс ЖМС-ын анхан шатны баримтуудыг шалган үзэхэд хүний сугалааны дугаартай баримт 1.1 сая төгрөг, хүчин төгөлдөр бус баримт 5.8 сая төгрөг, нийт 6.9 сая төгрөгийн хүчингүй баримт байна.	6.9			
3	2019 оны 12 сарын 31-ний байдлаар орлогын тайлангийн үйл ажиллагааны зардлаас түүвэрлэн шалгахад нийт зардлын ангилал зөрүүтэй 58.1 сая төгрөг байна. Үүнээс 47.2 сая төгрөгийн зардал нь татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал, үлдсэн 10.8 сая төгрөгийн зардал нь үндсэн үйл ажиллагааны зардлын дансны буруу ангилалтай байна.	58.1	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	Р.Батсүх, Д.Даваадорж
4	Санхүүгийн тайлангийн үндсэн бүрэлдэхүүн болох Мөнгөн гүйлгээний тайланг өмнөх оны дүнтэй зэрэгцүүлэн илэрхийлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-тай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	Р.Батсүх, Д.Даваадорж

5	<p>Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын дагуу “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд хийгдсэн гэрээт ажлуудын төлбөрийг Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх, санхүүжилтийг улсын төсвөөс эргэн төлөхөөр шийдвэрлэсэн боловч уг санхүүжилт зохих ёсоор олгогдоогүй байна. Ажил гүйцэтгэгч нарын нэхэмжлэлээр үүссэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй 10,417.7 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1.”Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, 6 дугаар зүйлийн 6.1 ”Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалт, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” гэсэнтэй нийцээгүй, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.</p>	10,417.7	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	Р.Батсүх, Д.Даваадорж
	Дүн	10,491.1			

